



ХАН-УУЛ
ДҮҮРГИЙН
НИЙГЭМ,
ЭДИЙН
ЗАСГИЙН
БАЙДАЛ

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2022/04



<http://www.ubstat.mn>

АГУУЛГА

	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020–2022 ОН	2
	БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	3
	НИЙГМИЙН ДААТГАЛ	4
	НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
	ЭРҮҮЛ МЭНД	7
	АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	8
	ГЭМТ ХЭРЭГ	10
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	12
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	14
	ХӨДӨӨ АЖ АХУЙ	18
	АЖ ҮЙЛДВЭР	19
	БАРИЛГА	22
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	23

ХҮСНЭГТ 1. ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн I-IV сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	188 582	197 274	210 588
Шинээр төрсөн хүүхэд	тоо	1 557	1 613	1 371
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	574	434	690
үүнээс: эмэгтэй	хүн	296	227	356
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	399	3 277	24 010
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	587	712	1 028
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	-0.5	3.4	2.9
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	2 783.0	2 850.0	3 083.9
Дүүргийн төсвийн орлого	сая төгрөг	33 028.9	53 783.9	67 405.2
Дүүргийн төсвийн зарлага	сая төгрөг	30 238.7	27 575.7	40 894.6



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2022 оны 4 дүгээр сард 690 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 256 хүнээр нэмэгдсэн байна. Нийт ажилгүйчүүдийн 356 (51.6 %) эмэгтэйчүүд байна.

2022 оны 4 дүгээр сард орон тооны цомхотголоор 20, мэргэжил, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй 2, өөр газраас шилжиж ирсэн 6, сургууль төгссөн 4, бусад шалтгаанаар 247 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 23 ажилд орсноос төсөвт байгууллагад 8, нөхөрлөл компанид 14, бусад байгууллагад 1 хүн ажилд орсон.

ХҮСНЭГТ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролын түвшнээр, 2022 IV сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2020 IV	2021 IV	2022 IV	2020 IV	2021 IV	2022 IV
Нийт ажилгүйчүүд	574	434	690	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	300	179	377	52.3	41.2	54.6
Тусгай дунд боловсролтой	25	18	34	4.4	4.1	5.0
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	24	20	21	4.2	4.6	3.0
Бүрэн дунд боловсролтой	219	192	243	38.1	44.2	35.2
Бүрэн бус дунд боловсролтой	3	21	10	0.5	4.9	1.5
Бага, боловсролгүй	3	4	5	0.5	1.0	0.7

ЗУРАГ 1. АЖИЛГҮЙЧҮҮД насны бүлгээр, 2022 IV сард



2022 оны 4 дүгээр сард 279 хүн шинээр бүртгүүлсэн байгааг ажил хайж буй шалтгаанаар нь авч үзвэл 237 (85.0%) хүн ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 24 (3.5%) нь 15-24 насны, 267 (38.7%) нь 25-34 насны, 234 (33.9%) нь 35-44 насны, 165 (23.9%) нь 45-60 насны хүмүүс байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

2022 оны эхний 4 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 4 909 байгууллагын нийт 122.3 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 78 882 (64.5%) нь ААНБ-ын, 11 209 (9.1%) нь төсвийн байгууллагын, 7 155 (5.9%) нь сайн дурын даатгуулагчид, 25 022 (20.5%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГААР ҮЙЛЧЛҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА БОЛОН ДААТГУУЛАГЧИЙН ТОО, 2022 оны эхний IV сард

Үзүүлэлт	2021 I-IV	2022 I-IV	Өсөлт/ Бууралт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	4 359	4 909	550	12.6
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	4 237	4 783	546	12.9
Төсөвт байгууллагын тоо	122	126	4	3.3
Нийт даатгуулагчдын тоо	102 186	122 268	20 082	19.7
ААНБ-ын даатгуулагчийн тоо	69 969	78 882	8 913	12.7
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	10 670	11 209	539	5.1
Сайн дурын даатгуулагчийн тоо	6 706	7 155	449	6.7
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	14 841	25 022	10 181	68.6

2022 оны эхний 4 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 104.8 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 3.7 (3.7%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.5 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2022 оны эхний IV сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2021 I-IV	2022 I-IV	2021 I-IV	2022 I-IV	2021 I-IV	2022 I-IV
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	39 185.7	50 359.5	36 719.4	54 056.9	93.7	107.3
Тэтгэмжийн сангийн орлого	2 891.0	5 161.7	4 717.5	5 722.3	163.2	110.9
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	2 895.6	4 437.0	4 408.7	4 431.7	152.3	99.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	581.7	1 105.5	965.3	1 084.2	165.9	98.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	10 219.6	12 052.0	10 219.6	12 052.0	100.0	100.0
Нийт	55 773.6	73 115.7	57 030.5	77 347.1	102.3	105.8


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 69.5 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.5 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 6 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.4 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 15.6 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 18 133 хүнд 43.1 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3 348 хүнд 5.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 886 хүнд 1.5 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1305 хүнд 4.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 7566 хүнд 1.2 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 1635 хүнд 3.5 тэрбум төгрөгийг, 16 хүнд оршуулгын тэтгэмж 16 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 160 хүнд 398.8 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 19 хүнд 58.3 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 35 хүнд 26.8 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1 005 хүнд 2.9 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 73.1 хувийг тэтгэврийн, 6.6 хувийг тэтгэмжийн, 5.2 хувийг ҮОМШӨ-ний, 2.4 хувийг ажилгүйдлийн, 12.7 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ЗУРАГ 4. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг



ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО





НИЙГМИЙН ХАЛАМЖ

2022 оны эхний 4 сард нийгмийн халамжийн сангийн олголтын мэдээгээр нийт 10.7 хувь нь нийгмийн халамжийн сан, 79.4 хувь нь хүүхдийн мөнгө, 0.6 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 2.9 хувь нь алдарт эхийн одонгийн тусламж, 1.7 хувь нь насны хишиг, 4.4 хувь нь цалинтай ээж хөтөлбөр, 0.3 хувь нь ахмад цолтон, өрх толгойлсон эцэг эх, онцгой тохиолдлын орлогод тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 79.5 хувь нь хүүхдийн мөнгө буюу нийт 89 131 хүнд, 10 534 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 28 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 13 779 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2022 оны эхний IV сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	44 686.2	
Улсын төсвийн санхүүжилтийн орлого	44 686.2	
Нийгмийн халамжийн сан	4 772.7	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	271.1	
Алдарт эхийн одонгийн тусламж	1 281.3	
Насны хишиг	782.3	
Хүүхдийн мөнгө	35 475.0	
Цалинтай ээж хөтөлбөр	1 950.2	
Ахмад цолтон ахмадын хөнгөлөлт, тусламж	9.3	
Өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	131.1	
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	13.2	
Зарлагын нийт дүн	44 636.2	131 660
Нийгмийн халамжийн сан	4 722.7	8 686
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	2 352.4	13 779
Алдарт эхийн одонгийн тусламж	1 281.3	10 534
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	9.3	28
Хүүхдийн мөнгө	35 475.0	89 131
Насны хишиг	782.3	9 491
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	13.2	11



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 4 сард 24 010 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 20 733 хүнээр (7.3 дахин), 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1 070.3 продицимилээр нэмэгдсэн байна.


Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 99.2 хувийг ковид-19, 0.3 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 0.3 хувийг салхин цэцэг, 0.1 хувийг цусан суулга, 0.1 хувийг тэмбүү өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний IV сард


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 I-IV	2022 I-IV	Өсөлт, бууралт 2022/2021	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	3 277 171.9	24 010 1242.4	20733 1070.5	7.3¹
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	1 0.1	5 0.3	4 0.2	5 ¹
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	0 0	22 1.1	22 1.1	0
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	0 0	2 0.1	2 0.1	0
Сальмонеллөз	Бодит тоо 10000 хүнд	0 0	5 0.3	5 0.3	0
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	0 0	61 3.2	61 3.2	0
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	0 0	1 0.1	1 0.1	0
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	0 0	2 0.1	2 0.1	0
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	0 0	6 0.3	6 0.3	0
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	16 0.8	26 1.3	10 0.5	62.5
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	19 1.0	4 0.2	-15 -0.8	-78.9
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	16 0.8	2 0.1	-14 -0.7	-87.5
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	54 2.8	64 3.3	10 0.5	18.5
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	0 0	-2 -0.1	-100.0
Ковид 19	Бодит тоо 10000 хүнд	3 167 166.2	23 810 1 232.0	20 643 1 065.8	7.5 ¹
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	0 0	2 0.1	-100.0

¹ дахин их

ЗУРАГ 6. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



ЗУРАГ 7. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД



2022 оны эхний 4 сард төрөхийн улмаас эндсэн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 1 эхээр, нялхсын эндэгдэл 3 хүүхдээр, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 хүүхдээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 7. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний IV сард

Үзүүлэлт	2020 I-IV	2021 I-IV	2022 I-IV	$\frac{2022}{2021}$ %
Амаржсан эхийн тоо	1 547	1 597	1 366	-14.5
Амьд төрсөн хүүхэд	1 557	1 613	1 371	-15.0
Төрөхийн улмаас эндсэн эх	-	1	2	100.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	11	14	27.3
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	-	2	3	50.0

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2022 оны 4 дүгээр сард дунджаар 3.4°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.3°C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 0.4°C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 21.0°C, хамгийн хүйтэн хэм -9.7°C, хур тунадасны нийлбэр 6.6 миллиметр, цасан бүрхүүлийн зузаан 7 см, шороон болон цасан шуургатай өдөр 4, салхины үнэмлэхүй их хурд 24 метр секунд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 8. АГААРЫН БОХИРДОЛТ, мг/м³, IV сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	305	0.263	78	0.049
Азотын давхар исэл	NO ₂	0.050	264	0.091	81	0.040
Тоосжилт	PM ₁₀	0.100	346	0.684	102	0.088
	PM _{2.5}	0.050	253	0.096	33	0.026
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	999	8.531	-	1.042
Озон	O ₃	0.100	253	0.096	33	0.026

¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2022 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.013 мг/м^3 (35.7%)-ээр, $\text{PM}_{2.5}$ тоосонцорын дундаж агууламж 0.009 мг/м^3 (56.7%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.015 мг/м^3 (59.5%)-ээр, PM_{10} тоосонцрын дундаж агууламж 0.025 мг/м^3 (38.9%)-ээр тус тус их байна.

ХҮСНЭГТ 9. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м^3 , IV сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл-Экспо төв			Богд хааны ордон музей	Нисэх		
		2020	2021	2022	2022	2020	2021	2022
		Мг/м^3						
Хүхэрлэг хий SO_2	Дундаж	0.024	0.024	0.026	0.019	0.006	0.026	-
	Хамгийн их XXX*-с	0.047	0.056	0.137	0.036	0.012	0.055	-
	давсан хувь	-	3.0	4.0	-	-	3.0	-
	Хэмжилтийн тоо	31	29	28	30	26	30	-
Азотын давхар исэл NO_2	Дундаж	-	0.029	-	0.034	0.015	0.017	0.024
	Хамгийн их XXX*-с	-	0.045	-	0.055	0.025	0.034	0.039
	давсан хувь	-	-	-	7.0	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	28	-	27	25	30	22
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO^{**}	Дундаж	-	-	0.562	0.443	-	0.591	0.791
	Хамгийн их XXX*-с	-	-	2.891	1.317	-	1.791	2.548
	давсан хувь	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	87	90	-	90	79
Тоос PM_{10}	Дундаж	0.051	0.072	0.057	0.060	0.145	0.059	-
	Хамгийн их XXX*-с	0.119	0.149	0.185	0.241	0.224	0.208	-
	давсан хувь	3.0	21.0	7.0	7.0	81.0	17.0	-
	Хэмжилтийн тоо	31	24	30	30	26	30	-
Тоос $\text{PM}_{2.5}$	Дундаж	-	-	-	0.006	0.032	0.016	0.048
	Хамгийн их XXX*-с	-	-	-	0.025	0.049	0.041	0.07
	давсан хувь	-	-	-	-	-	-	41.0
	Хэмжилтийн тоо	-	-	-	30	26	30	22
Озон O_3^{**}	Дундаж	0.019	0.022	-	0.006	-	0.072	0.048
	Хамгийн их XXX*-с	0.048	0.036	-	0.025	-	0.108	0.07
	давсан хувь	-	-	-	-	-	5.0	41.0
	Хэмжилтийн тоо	93	90	-	30	-	90	22

* Хүлцэх хэм хэмжээ, **CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2022 оны 4-р сарын танилцуулга

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгч 120 дахин бага, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 51.3 дахин, амоны азот 76.5 дахин, эрдэс фосфор 19.8 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

ХҮСНЭГТ 10. НИЙСЛЭЛИЙН ГАДАРГЫН УСНЫ НАЙРЛАГА, мг/м³, IV сард³


Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	10.27	Хэвийн	0.05	120 дахин бага
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤ 3	2.4	Хэвийн	154	51.3 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.005	Хэвийн	0.013	Хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.02	Хэвийн	38.3	76.5 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.008	Хэвийн	1.975	19.8 дахин



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 4 сард 1 028 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 316 (44.4%) хэргээр өссөн байна.

ЗУРАГ 8. ГЭМТ ХЭРГИЙН ТОО, жил бүрийн I-IV сард



Нийт гэмт хэргийн 220 (21.4%) нь хулгайн хэрэг, 220 (21.4%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 361 (35.1%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 8 (0.8%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 9 (0.9%) нь хүчингийн хэрэг, 10 (0.9%) нь дээрэмдэх хэрэг, 30 (2.9%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 11 (1.1%) нь хүнийг алах хэрэг, 2 (0.2%) нь малын хулгай, 157 (15.3%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

³ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори


ХҮСНЭГТ 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, IV сард

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2021 I-IV	2022 I-IV	$\frac{2022}{2021}\%$	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	9	8	-11.1	-1
Хүчин	4	9	2.2 ¹	5
Дээрэмдэх	7	10	42.8	3
Хулгай	98	220	2.2 ¹	122
Залилан мэхлэх	259	361	39.4	102
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	112	220	96.4	108
Малын хулгай	-	2	-	2
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	-	-	-
Хүнийг санаатай алах	1	11	11 ¹	10
ХАБТХАЖЭ	20	30	50.0	10
Бусад	202	157	-22.3	-45
Бүгд	712	1 028	44.4	316

*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт 220 хулгайн гэмт хэргийн 192 (87.3%) нь иргэний өмчийн хулгай, 28 (12.7%) нь халаасны хулгайн хэрэг эзэлж байна.

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор



ХҮСНЭГТ 12. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэл	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	ХАБТХАЖЭ	Бусад
	2021 I-IV	2022 I-IV	Тоо	Хувь							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
Дүн	712	1 028	316	44.4	11	8	220	1	9	220	192	-	28	10	361	2	-	30	157
1	34	58	24	70.6	1	2	8	-	2	10	8	-	2	2	22	-	-	1	10
2	41	47	6	14.6	-	-	14	-	-	7	7	-	-	-	24	-	-	-	2
3	77	70	-7	9.1	1	-	15	-	-	8	7	-	1	-	28	-	-	3	15
4	58	144	86	2.5 ¹	1	1	25	-	-	40	31	-	9	1	53	-	-	6	17
5	7	15	8	2.1 ¹	-	-	2	-	-	3	3	-	-	-	4	-	-	3	3
6	8	12	4	50.0	-	1	2	-	-	1	-	-	1	1	7	-	-	-	-
7	6	14	8	2.3 ¹	-	-	4	-	-	2	2	-	-	-	5	-	-	-	3
8	33	47	14	42.4	2	-	12	-	2	11	11	-	-	1	10	1	-	1	7
9	13	25	12	92.3	-	-	7	-	3	11	11	-	-	-	4	-	-	-	-
10	23	38	15	65.2	2	-	9	-	-	4	4	-	-	1	18	-	-	-	4
11	95	83	-12	-12.6	1	1	19	1	-	11	11	-	-	-	31	-	-	5	15
12	10	22	12	2.2 ¹	-	-	4	-	-	7	7	-	-	-	6	-	-	-	5
13	9	14	5	55.5	-	1	3	-	-	3	3	-	-	-	6	-	-	-	1
14	15	36	11	2.4 ¹	-	-	5	-	-	14	13	-	1	-	5	1	-	4	7
15	111	140	29	26.1	-	-	33	-	-	25	19	-	6	1	51	-	-	4	26
16	30	58	28	93.3	1	1	10	-	1	26	22	-	4	1	12	-	-	2	4
17	29	32	3	10.3	1	-	10	-	-	4	4	-	-	1	10	-	-	-	6
18	18	27	9	50.0	-	-	9	-	-	4	4	-	-	-	8	-	-	1	5
19	44	39	-5	-11.4	-	1	9	-	-	3	3	-	-	-	21	-	-	-	5
20	34	54	20	58.8	-	-	13	-	1	8	7	-	1	1	21	-	-	-	10
21	17	53	36	3.1 ¹	1	-	7	-	-	18	15	-	3	-	15	-	-	-	12

*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг


¹ дахин их



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2022 оны эхний 4 сард 67.4 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 6.9 (9.3%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2021 оноос 25.3 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 95.5 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 4.5 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 10. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2013-2022 онд, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 64.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 8.4 (11.6%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бол, татварын бус орлого 3.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.5 (98.1%) тэрбум төгрөгөөр тус тус илүү бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 13. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2022 оны эхний IV сард, сая төгрөг

Төсвийн орлого			Үүнээс:						
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	67 405.2	90.7	-6 922.5	64 389.1	88.4	-8 416.2	3 016.1	198.1	1 493.7

Орлогын албан татвар төлөвлөснөөс 12.6 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 0.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн бол бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 4.5 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 14. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2022 оны эхний IV сард, сая.төг


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	74 327.7	67 405.2	90.7	-6 922.5
1.Татварын орлогын дүн	72 805.3	64 389.1	88.4	-8 416.2
1.1 Орлогын албан татвар	61 770.3	49 120.8	79.5	-12 649.4
Хувь хүний орлогын албан татвар	61 770.3	49 120.8	79.5	-12 649.4
1.2 Хөрөнгийн албан татвар	4 224	3 957.1	93.7	-266.9
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	6 811	11 311.2	166.1	4 500.2
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2 011	1 820.3	90.5	-190.7
Улсын тэмдэгтийн хураамж	1 700	1 117.5	65.7	-582.5
Ашигт малтмал ашигласны төлбөр	11	67.6	614.8	56.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	300	635.1	211.7	335.1
1.3.2 Газрын төлбөр	4 800	9 480	197.5	4680
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0	10.9	0	10.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0	10.9	0	10.9
2.Татварын бус орлогын дүн	1 522.4	3 016.1	198.1	1 493.7
Нийтлэг бус татварын орлого	1 181.4	2 688.1	227.5	1 506.7
Торгуулийн орлого	1 100	2 589.5	235.4	1 489.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	69.4	80.8	116.4	11.4
Бусад орлого	12	17.8	148.5	5.8
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	341	328	96.2	-13
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	0	0	0	0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	341	328	96.2	-13

*Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

ЗУРАГ 11. ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 12. ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



2022 оны эхний 4 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 40.9 (47.0%) тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 46.2 (53.0%) тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 9.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 1.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 89.0 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2022 оны эхний IV сард, сая төгрөг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	67 405.2	87 075.3	40 894.6	47.0	-46 180.8	26 510.6

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 55.4 сая төгрөг байсан бөгөөд 25.0 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, тухайн сардаа 49.2 сая төгрөг төлөгдөж сарын эцэст 31.2 сая төгрөгний өглөгтэй болсон байна.

ХҮСНЭГТ 16. ӨГЛӨГ, 2022 оны эхний IV сард, сая.төг


	3-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	3-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	55.4	25.0	49.2	31.2



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өслөө. 2022 оны 4 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2021 оны жилийн эцэстэй харьцуулахад 7.2 хувь, өмнөх сартай харьцуулахад 2.9 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 13. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2022 оны 4 дүгээр сарыг жилийн эцэстэй харьцуулахад 7.2 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 8.8 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 2.6 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 8.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 14.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 7.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 12.2 хувь, тээврийн бүлгийн үнэ 4.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 1.9 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 0.9 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 7.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 17 . ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2021 IV 2020 IV	2022 IV 2021 IV	2022 IV 2021 XII	2022 IV 2022 III
Ерөнхий индекс	106.0	115.2	107.2	102.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	113.3	116.9	108.8	103.0
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.1	109.4	102.6	101.1
Хувцас, бөс бараа, гутал	101.5	113.9	108.4	101.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	108.4	110.6	114.9	112.2
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.9	113.3	107.2	102.0
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	104.5	118.9	112.2	101.1
Тээвэр	99.3	125.8	104.4	101.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.3	105.6	101.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	101.0	103.6	101.2	100.5
Боловсролын үйлчилгээ	101.4	105.9	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	108.7	116.7	100.9	100.0
Бусад бараа, үйлчилгээ	105.8	118.3	107.8	101.7

2022 оны 4 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 47.7 хувийнх нь үнэ өсөж, 5.8 хувийнх нь үнэ буурч, 46.5 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

ХҮСНЭГТ 18. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /**эерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	1.4	Энэ бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний үнэ 2.9 хувиар, гоймонгийн үнэ 3.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	1.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд шар айргийн үнэ 7.9 хувиар шууд нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	1.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хүүхдийн бэлэн хувцасны үнэ 4.0 хувиар, бүх төрлийн гутлын үнэ 3.9 хувиар тус тус голлон нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	12.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хатуу түлшний үнэ 28.9 хувиар, сууц хөлслөгчийн төлсөн бодит түрээсийн үнэ 4.9 хувиар, орон сууцны техникийн болон засвар үйлчилгээний үнэ 4.5 хувиар тус тус нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	2.0	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн шилэн эдлэл, сав суулгын үнэ 4.5 хувиар, гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг бараа, гэрийн үйлчилгээний үнэ 3.3 хувиар тус тус нөлөөлөв.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд амбулаторийн үйлчилгээний үнэ 8.1 хувиар шууд нөлөөлөв.
Тээвэр	1.4	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний үнэ 2.7 хувиар шууд нөлөөлөв.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд чөлөөт цагт зориулсан тоглоомын үнэ 6.1 хувиар, үзвэр үйлчилгээний үнэ 1.1 хувиар тус тус голлон нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	1.7	Энэ бүлгийн үнийн өсөлтөд цүнх, чемодан, түрийвчний үнэ 9.9 хувиар, бусад үйлчилгээний үнэ 6.4 хувиар тус тус голлон нөлөөлжээ.


2022 оны 4 дугаар сарын 27-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Манжин 1550 төгрөг, Лууван 1200 төгрөг, Төмс 800 төгрөг, Тараг, цэцгийтэй, “Сүү” ХК 790 төгрөг, Задгай сүү 600 төгрөг, “Хонины мах”, ястай 500 төгрөг, “Үхрийн мах”, ястай 500 төгрөг, Элсэн чихэр 324 төгрөг, Байцаа 200 төгрөг, Фүжи алим 100 төгрөгөөр тус тус өссөн. Сонгино 2800 төгрөгөөр буурсан. Харин “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ 1300 төгрөг, Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 1650 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 1400 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 1050 төгрөг, Цагаан будаа 2775 төгрөгөөр тус тус тогтвортой байлаа.

ХҮСНЭГТ 19. ХҮНСНИЙ ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн IV сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2021 IV	2022 IV	$\frac{2022}{2021} \%$
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1300	1300	100.0
Хонины мах, ястай	Кг	12500	13000	104.0
Үхрийн мах, ястай	Кг	12500	13000	104.0
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа”	Кг	1650	1650	100.0
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1400	1400	100.0
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК,	Кг	1050	1050	100.0
Элсэн чихэр	Кг	1350	1674	124.0
Төмс, монгол	Кг	1000	1800	180.0
Байцаа, монгол	Кг	3300	3500	106.1
Лууван, монгол	Кг	1300	2500	192.3
Манжин, монгол	Кг	2250	3800	168.9
Сонгино, хятад	Кг	6000	3200	53.3
Цагаан будаа	Кг	2775	2775	100.0
Алим, фүжи	Кг	7500	7600	101.3
Сүү, задгай	литр	1600	2200	137.5
Тараг, цөцгийтэй, “Сүү ” ХК	литр	2780	3570	128.4

* Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


ЗУРАГ 14. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг




ЗУРАГ 15. НЭГ КГ ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, төгрөг



ЗУРАГ 16. НЭГ КГ ТӨМС, ЛУУВАН, БАЙЦААНЫ дундаж үнэ, төгрөг



ЗУРАГ 17. НЭГ КГ МАНЖИН, СОНГИНЫ дундаж үнэ, төгрөг



ХҮСНЭГТ 20. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2021.IV.28					2022.IV.27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель тулш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель тулш	Газ
Жаст Ойл	-	1 300	1 370	1 960	-	3 190	-	-	-	-
Петровис	2 100	1 400	1 450	2 190	-	3 260	2 370	2 390	3 380	-
Магнай трейд	2 100	-	1 450	2 190	-	3 260	-	2 390	3 380	-
Сод монгол	2 100	-	1 450	2 190	-	3 260	-	2 385	3 380	-
Шунхлай	2 100	-	1 450	2 190	-	3 260	-	2 390	3 380	-
Юнигаз	-	-	-	-	1 130	-	-	-	-	1 690
Дундаж үнэ	2 100	1 350	1 434	2 144	1 130	3 246	2 370	2 389	3 380	1 690

Эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 4-р сарын мэдээ



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 4 сард 5 418 хээлтэгч мал төллөжээ. Нийт гарсан төлөөс 161 (3.0%) нь хорогдож, 5 257 (97.0%) төл бойжиж байна.

ХҮСНЭГТ 21. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, жил бүрийн эхний 4 сард


Үзүүлэлт	2021 I-IV	2022 I-IV	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Төллөсөн хээлтэгч мал	4 740	5 418	-	150	1 670	1 836	1 762
Гарсан төл	4 751	5 418	-	150	1 670	1 836	1 762
Үүнээс: Хорогдсон төл	46	161	-	3	12	54	92
Бойжсон төл	4 705	5 257	-	147	1 658	1 782	1 670

Бойжсон нийт төлийн 2.8 хувийг унага, 31.5 хувийг тугал, 33.9 хувийг хурга, 31.8 хувийг ишиг эзэлж байна.

ХҮСНЭГТ 22. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн эхний 4 сард

Үзүүлэлт	2021 I-IV	2022 I-IV	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	1 196	141	-	23	48	23	47
Үүнээс: өвчнөөр хорогдсон	0	0	-	-	-	-	-
Хорогдсон хээлтэгч	319	29	-	4	12	5	8

ЗУРАГ 18. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, эхний 4 сард






АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн байгууллагууд 2022 оны эхний 4 сард 384.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 470.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 124.7 хувиар, борлуулалт 113.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 19. АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, 2021-2022 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 449.3 тэрбум төгрөгийг дотоодод, 21.5 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 4.6 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 74.2 хувийг хувцас үйлдвэрлэл, 0.8 хувийг ээрэх нэхэх даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл, 24.1 хувийг ундаа үйлдвэрлэл, 0.7 хувийг мах боловсруулах үйлдвэрлэл, 0.1 хувийг арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 0.1 хувийг машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл тус тус эзэлж байна.

ЗУРАГ 20. ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2020-2022 он, тэрбум төг



ЗУРАГ 21. БОРЛУУЛАЛТ, 2020-2022 он, тэрбум төг



ХҮСНЭГТ 23. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2021 I-IV	2022 I-IV	$\frac{2022}{2021}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	464.1	1 364.8	2.9 ¹
Металлын хүдэр олборлолт	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	464.1	1 364.8	2.9 ¹
Боловсруулах үйлдвэр	254 220.6	325 667.5	128.1
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	159 990.7	192 239.4	120.2
Мах боловсруулах, консервлох	1 763.8	1 319.2	74.8
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	1 263.7	1 731.4	137.0
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	35 376.1	42 053.4	118.9
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9 568.9	14 571.5	152.3
Малын тэжээл үйлдвэрлэл	5 772.2	1 644.7	28.5
Ундаа үйлдвэрлэл	106 246.0	130 919.2	123.2
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	25 974.8	24 707.1	95.1
Хувцас үйлдвэрлэл	20 541.9	56 751.1	2.8 ¹
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 241.7	1 533.6	123.5
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 834.2	11 762.0	108.6
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	4 432.0	3 933.8	88.8
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18 163.3	8 779.0	48.3
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	5 162.7	7 224.5	139.9
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 353.4	1 276.2	94.3
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	1 571.8	3 175.2	2.0 ¹
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	812.4	867.4	106.8
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	63.8	150.5	2.3 ¹
Тавилга үйлдвэрлэл	1 420.3	1 995.2	140.5
Бусад боловсруулах үйлдвэрлэл	205.9	6 597.9	32.0 ¹
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	2 451.7	4 674.6	190.7
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	50 682.0	56 638.8	111.8
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3 111.1	1 029.9	33.1
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	224.8	1 029.9	4.6 ¹
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	2 886.3	0.0	0.0
ДҮН	308 477.8	384 701.0	124.7

Тайлбар: Дүүргийн аж ахуйн нэгж байгууллага нэмэгдэж, хасагдаснаас шалтгаалж өөрчлөлт орсон.

¹ дахин их

ХҮСНЭГТ 24. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2021 I-IV	2022 I-IV	$\frac{2022}{2021}$ %	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	464.1	1 364.8	2.9 ¹	-
Металлын хүдэр олборлолт	-	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	464.1	1 364.8	2.9 ¹	-
Боловсруулах үйлдвэр	359 901.6	411 936.4	114.5	100.0
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	259 705.9	297 254.2	114.5	-
Мах боловсруулах, консервлох	2 338.4	1 144.8	49.0	0.7
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	1 175.6	1 805.6	153.6	-
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	53 529.3	56 427.7	105.4	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9 741.6	14 731.4	151.2	-
Малын тэжээл үйлдвэрлэл	5 772.2	1 644.7	28.5	-
Ундаа үйлдвэрлэл	187 148.8	221 500.0	118.4	24.1
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	30 501.5	20 907.7	68.5	0.8
Хувцас үйлдвэрлэл	18 676.5	40 023.2	2.1 ¹	74.2
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 414.8	1 574.5	111.3	0.1
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10 993.0	11 839.8	107.7	-
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	4 432.0	3 933.8	88.8	-
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18 212.3	8 869.1	48.7	-
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	7 996.9	8 904.0	111.3	-
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 353.4	1 276.3	94.3	-
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	1 586.2	3 248.4	2.0 ¹	-
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	822.0	793.4	96.5	0.1
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	63.8	150.5	2.3 ¹	-
Тавилга үйлдвэрлэл	1 412.6	2 051.5	145.2	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	279.0	6 645.4	23.8 ¹	-
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	2 451.7	4 464.6	182.1	-
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	50 682.0	56 638.8	111.8	-
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3 300.2	909.7	27.6	-
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	224.8	909.7	27.6	-
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	3 075.4	-	-	-
ДҮН	414 347.9	470 849.7	113.6	-

Тайлбар: Дүүргийн аж ахуйн нэгж байгууллага нэмэгдэж, хасагдаснаас шалтгаалж өөрчлөлт орсон.

¹ дахин их



БАРИЛГА

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны эхний улирлын байдлаар нийт 198866.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 377 барилга, байгууламж баригдаж байна. Эдгээр барилга байгууламжийн 32261.6 тэрбум төгрөгийн (16.2%) өртөг бүхий барилга нь төрийн болон орон нутгийн өмчийн, 166604.9 тэрбум төгрөгийн (83.8%) өртөг бүхий барилга нь иргэний болон хувийн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Мөн баригдаж буй объектуудыг давхарын хувьд бүлэглэн авч үзвэл 1-5 давхар (10.8%), 6-10 давхар (12.7%), 11-ээс дээш давхар (76.5%) эзэлж байна. Нийт гүйцэтгэлийн (99.4%) шинэ барилга, өргөтгөлийн ажил, (0.6%) их засварын ажил эзэлж байна. Шинэ барилга, өргөтгөл шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлийн (73.3%) орон сууцны барилга байгууламжийн ажил эзэлж байна.

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2022 оны 4 дүгээр сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 506 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд нь 790 өргөдөл, гомдолд хариу өгч, хугацаа хэтэрсэн 5, шийдвэрлэх хугацаа болоогүй 95 өргөдөл байна.

ХҮСНЭГТ 25. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга					Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим	Гомдол	Санал	Талархал	Мэдэгдэл	Хүсэлт					
Удирдлага	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ТЗУХ	25	-	11	14	-	16	-	-	-	9	-	25	-	-	-
СТСХ	2	-	2	-	-	-	-	-	-	2	-	1	-	1	-
ТГХХ	24	-	12	8	4	4	1	-	-	19	-	20	-	4	-
НХХ	24	-	20	4	-	3	-	-	-	21	-	21	-	3	-
ХОБЗХ	50	-	10	37	3	39	1	-	-	10	-	42	-	8	-
ТНБГХХ	22	-	4	15	3	10	3	-	1	8	-	18	-	4	-
ХХҮХ	7	-	2	5	-	4	-	-	-	3	-	5	-	2	-
ХЗТ	15	-	12	2	1	3	-	-	1	11	-	13	-	2	-
Цэргийн штаб	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЗДТГ-ын дүн	169	-	73	85	11	79	5	-	2	83	-	145	-	24	-
ХөХҮХ	58	-	48	10	-	5	-	2	-	51	-	57	-	1	-
Газрын алба	411	-	363	42	6	40	5	-	1	365	-	368	-	43	-
Боловсролын хэлтэс	17	-	2	15	-	14	1	-	-	2	-	13	-	4	-
ОБХ	1	-	-	-	1	-	-	-	-	1	-	1	-	-	-
Албан бус-НТБ төв	3	-	3	-	-	-	-	-	-	3	-	3	-	-	-
Бүртгэлийн хэлтэс	13	-	-	12	1	11	2	-	-	-	-	11	-	1	1
ГБХЗХХ	49	-	49	-	-	-	-	-	-	49	-	44	-	5	-
МХХ	98	-	17	76	5	93	-	-	-	5	-	89	-	7	2
Татварын хэлтэс	9	-	3	5	1	7	-	-	-	2	-	6	-	1	2
НДХ	37	-	34	3	-	15	-	-	-	22	-	34	-	3	-
Цагдаагийн газар	25	-	2	23	-	13	-	9	-	3	-	19	-	6	-
Дэргэдэх хэлтэс, албадын дүн	721	-	521	186	14	198	8	11	1	503	-	645	-	71	5
Нийт дүн	890	0	594	271	25	277	13	11	3	586	0	790	0	95	5

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Танилцуулгыг эрхлэн гаргасан: Ахлах мэргэжилтэн Б.Тодмаа



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2022 оны эхний 4 сар



Амаржсан эх

Төрсөн хүүхэд



2021 I-IV

1 597

2022 I-IV

1 366



2021 I-IV

1 613

2022 I-IV

1 371



Халдварт өвчнөөр
өвчлөгчид



Бүртгэгдсэн гэмт хэрэг



2021 I-IV

3 277

2022 I-IV

24 010



2021 I-IV

712

2022 I-IV

1 028



Бүртгэлтэй ажилгүй иргэд



2021 IV

434

227

2022 IV

690

356



Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт

Үйлдвэрлэлт, тэрбум.төг

2021 I-IV 308.5

2022 I-IV 384.7

Борлуулалт, тэрбум.төг

2021 I-IV 414.3

2022 I-IV 470.8



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт, хувь



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн
индексийн жилийн өөрчлөлт, хувь

2021 IV 3.4

2022 IV 2.9



Валютын зах
зээлийн ханш

\$

1US\$ = ₮

2021 IV 2 850.0

2022 IV 3 083.9



Дүүргийн төсөв, сая.төг

Орлого

2021 I-IV 53 783.9

2022 I-IV 67 405.2



Зарлага

2021 I-IV 27 575.7

2022 I-IV 40 894.6

Дэлгэрэнгүйг: <http://www.ubstat.mn/Report> хуудаснаас авна уу

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn